

БИЕЛЭЛТ ТАЙЛАГНАСАН: ХҮННҮ СТИЙЛ” ХХК-ийн гүйцэтгэх
захирал.....О.Ганзориг

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН “ХУСТАЙН” ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл MV-017017/ Аж ахуйн нэгжийн регистрийн
дугаар 5378834/

Хянасан: БОУАӨЯ-ны ХБОБНУГ Ахлах шинжээч.....Ц.Жаргалнэмэх

Боловсруулсан: “Хүннү стийл” ХХК-ийн мэргэжилтэн.....Д.Даваадорж

ГАРЧИГ

- 1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....
- 2.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ.....
- 3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ.....
 - 3.1. Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний
төлөвлөгөөний биелэлт.....
 - 3.2. Амьтны аймаг, хөрс, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг
бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....
 - 3.3.Усан орчин, газрын гадрагад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга
хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....
 - 3.4.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт.....
 - 3.5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний
биелэлт.....
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
- 5.ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛ.....
- 6.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....
 - 6.1.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....
- 7.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
БИЕЛЭЛТ.....
- 8.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....
 - 8.1.Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

ОРШИЛ

“Хүннү стийл” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Төмрийн хүдрийг ил аргаар олборлох MV-017017 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгээр энэхүү төслийг хэрэгжүүлж байна.

Тус байгууллагын Хустай уурхай нь үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн талаар баримтлах бодлогын баримт бичиг, холбогдох салбаруудын хууль тогтоомж, төрөөс эрдэс баялагийн салбарт баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэгт тулгуурлан байгаль орчныг хамгаалах сайжруулах ажлыг хэрэгжүүлэн ажилласан.

Бид 2024 онд дараах чиглэлийг зорилго зорилт болгов. Үүнд:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;
- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авах;
- Ашигт малтмалын хайгуул хийх, барилга байгууламж барих, уурхайн олборлолт бауурхайн хаалт зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх;
- Компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;
- Нутгийн ард иргэдийн уламжлал, соёлыг хүндэтгэж хамгаалах;

“Хүннү стийл” ХХК нь “Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах, ил аргаар олборлох Хустай төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар журмын хавсралт 3 –ын дагуу боловсруулав.

1.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Хүннү стийл” ХХК нь Монгол улсын 5378834 тоот регистрийн дугаартай, 9011237003 тоот бүртгэлийн гэрчилгээтэй аж ахуйн нэгж нь “Хустайн” төмрийн ордын MV-017017 тоот дугаартай 84,73 га ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд 2012 оны нөөцийн үр дүнгийн тайлан батлагдсан уг талбайд төмрийн хүдрийн ордыг эргэлтэнд оруулах, Монгол улс дахь металлургийн үйлдвэрлэлийн түүхий эдийг бэлтгэх, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, бүс нутгийн үйлдвэрлэлийг дэмжих зэрэг олон эерэг талтай хэмээн үзэж уг ордыг ашиглахаар тусгай зөвшөөрөл авсан болно.

“Хустайн төмрийн орд нь засаг захиргааны нэгжийн хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах ба сумын төвөөс зүүн урагш 22 км-т, Аймгийн төвөөс зүүн урагш 102 км-т, Улаанбаатар хотоос хойд зүгт-т 330 км-т, Дархан-Уул аймгаас зүүн хойд зүгт 110 км-т байрлана.

Хустай уурхай нь анх байгуулагдсанаас хойш орон нутгийг иргэдийг ажлын байраар хангах бодлого барин ажиллаж байна. Тус уурхайд Улаанбаатар хот болон Дархан-Уул аймаг, орон нутгийн харъяалалтай 50-иад ажилтан ажиллаж байна.

Тус ашиглалтын талбайд 2012 онд хайгуулын ажил хийгдэж нийт хүдэр В нөөц 5.524.7 мян.тн, С нөөц 4.964.4 мян.тн, В+С нөөц 10.489.1 мян.тн батлагдсан.

2024 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хөрс хуулалт, хүдэр олборлолт, уулын цулын хэмжээг хүснэгтээр үзүүлэв.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Оны эхнээс		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Хөрс хуулалт	Метр куб	300960	136800	
2	Хүдэр олборлолт	Метр куб	78660	34200	
3	Уулын цул	Метр куб	379620	171000	

Батлагдсан нөөцийн дагуу ил уурхай, хуурай соронзон бажуулах үйлдвэр ажиллаж байгаа бөгөөд төмрийн хүдрийг гарган авахын тулд хуурай соронзон сеператорыг ашиглан баяжуулж байна.

Төмрийн хүдрийн ангилан ялгах хэсэг нь дараах дамжлагуудаас бүрдэнэ.

- 1.Хүдрийг буталж, боловсруулалтанд бэлдэх
- 2.Соронзон аргаар ялган, ангилах
- 3.Хаягдлыг хадгалах зэрэг болно.

Уурхайн үйл ажиллагааны технологийн дараалал:

- 1.Өрөмдлөг
- 2.Тэсэлгээ
- 3.Ухаж ачих
- 4.Тээвэрлэх
- 5.Хүдэр-Баяжуулах үйлдвэр

6.Хөрс-Гадаад овоолго



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын удирдамжаар томилогдсон Улсын комисс 2024 оны 07 дугаар 05-ны өдөр тус компанийн уурхай, үйлдвэрт ажиллаж үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүрдүүлбэл зохих бичиг баримттай танилцаад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/303 тоот тушаалаар баталсан журмын 2.2-т заасны дагуу “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээлгэн өгөх бэлтгэл ажил”-ыг хангасан гэж үзэн хүлээн авсан.

Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал: Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал цагт 100 тонн бөгөөд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 70-80%-тай ажиллах үед баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 60.0 тонн байна.

Ил уурхайгаас баяжуулах үйлдвэрт ирэх төмрийн хүдрийг /хүдрийн ширхэглэлийн хамгийн том хэмжээ 500x700 мм хүлээн авах бункерт хутгуурт ачигчийн тусламжтайгаар хийсэн хүдрийг дамжуулан PE 900x600 маркийн 1-р хацарт бутлуураар 0x120мм хүртэл

бутлан, HST-100 маркийн конусан бутлуураар 0-50 мм хүртэл бутлана.

0-50 мм-ийн бүхэллэгтэй хүдрийг S5x1860 маркийн 1-р шигшүүрээр ангилж, 0-35 мм хүдрийг VSI9526 маркийн инпакт бутлуур луу оруулж, 35 мм-ээс дээш бүхэллэгтэй хүдрийг дахин конусан бутлуурт оруулна.

0-35 мм хүдрийг импакт бутлуураар 0-10 мм хүртэл буталж S5x1860 маркийн 2-р шигшүүрээр 0-6мм, 6-10мм болгон хоёр ангилж соронзон сепратор луу дамжуулж баяжуулна.



Баяжуулах үйлдвэрийн барилгын суурийн болон угсралтын ажлыг “Цамхагт ундраа” ХХК зураг төслийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/284 тоот шийдвэрээр байгуулагдсан барилга байгууламжийг ашиглалтанд оруулах ажлын хэсэг /комисс/ 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хяналт шалгалт хийж бага, дунд төвөгшлийн ангилалын төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулах дүгнэлт гаргаж хүлээн авсан.

Эрчим хүчний хангамж: Хустайн төмрийн хүдрийн ордыг ашиглах төслийн хүрээнд цахилгаан хэрэглэгчид /баяжуулах үйлдвэр, уурхайн кемп/-ийн цахилгаан эрчим хүчийг Ерөө сумын нутагт байгаа Хустай 110/10 квт-ын дэд станцыг шинээр дахин сэргээн босгож эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан болно.

Шинээр сэргээхээс өмнө



Сэргээн босгосны дараа





Тэсэлгээний ажил: Уурхайн өрөмдлөг тэсэлгээний ажлыг мэргэжлийн байгууллага “Тэгш зорголон”ХХК -тай 2024 оны Г/005 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

Шатахуун түгээх станц: Хустай уурхай дахь шатахуун түгээх станц зөвхөн уурхайн үйл ажиллагааанд зориулагдсан ба уурхайн хүнд машин механизмуудыг дизель түлшээр тасралтгүй хангах үүрэгтэй ажиллаж байна. Түүний хангалт болон үйлчилгээг Шунхлай” ХХК-тай хийсэн гэрээний дагуу ханган ажиллаж байна.



Ашиглагдаж буй техник технологи:

№	Техникийн нэр, марк	Төлөв	Улсын дугаар
1	Экскаватор	Экскаватор	12-15 ук
2	Автосамосвал МТ-86	Дамп	87-52 уен
3	Автосамосвал МТ-86	Дамп	87-53 уен
4	Автосамосвал МТ-86	Дамп	87-51убү
5	Автосамосвал МТ-86	Дамп	87-56 уна
6	Ачигч /Ковш/	Ачигч	00-82 ур
7	Ачигч /Ковш/	Ачигч	13-52 ун
8	Портер ачааны машин	Ачааны	31-17 убб
9	Фургон автомашин	Суудлын	15-63 убх

10	RAV-4 суудлын машин	Суудлын	85-18унх
11	Өөрөө ачигч машин	Ачааны	18-90уеу
12	Hilux	Суудлын	38-44 унө

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Ил уурхайн олборлолтын явцад байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Ил уурхайн олборлолтын явцад анхаарах гол зүйл бол технологийн дагуу гүйцэтгэх, ил уурхайн ойр орчмын хөрс, ургамлан бүрхэвчийг хамгаалах явдал юм. Иймээс байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуух ажлуудыг хангаж ажилласан болно.

Байгаль орчны 2024 оны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө зэрэгт тусгагдсан арга хэмжээнүүдийн цаг тухайд нь авч хэрэгжүүлсэн.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2019 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам зэргийг удирдлага болгон ажилласан.

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахын дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэв. Үүнд:

1.Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарч ажиллаа.

2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажилласан.

3.Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад тогтмол хугацаанд сургалт зохион байгуулан ажилласан.

4.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны ХБОБНУГ-аар батлуулан ажиллаж байна.

5.2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №21 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд стандартын шаардлага хангаж байгаа нь шинжилгээний хариугаар гарсан.

6.Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-тай №49/10 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хашлага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж цэгцэлсэн.

7.Төлөвлөгөөт ажил дууссаны дараа ашиглалтын болон баяжуулах үйлдвэрийн талбайн хогийг цэвэрлэн Ерөө сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.

8.Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль

орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах зорилгоор “Хүннү стийл” ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргатай №03 тоот “Нийгмийн хариуцлагын гэрээ” байгуулан гэрээний хүрээнд орон нутагт Байгаль орчинг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг цаг тухайд нь танилцуулж харилцан уялдаатай ажиллав

9.Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний дагуу навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.

3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

3.1.Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
АГААР ОРЧИН			
1	Уурхайн дотоод тээврийн зам, овоолго зэргийг хуурайшилттай үед чийглэж байх	Дотоод тээврийн зам, овоолгын тоосжилтыг багасгахын тулд олборлолт явуулж байгаа талбай, овоолго, зам талбайг бороо хур ороогүй үед 7 хоногт 1-2 удаа усалж чийглэхийн зэрэгцээ уурхайн хөрс хуулах, гадаад овоолго, зам талбай барих ажлыг цаг агаарын нөхцөл байдалтай уялдуулан салхи багатай үед төлөвлөж, хийж байна.	12 сая төг
2	Уурхайн хүнд мөхөнизмууд, тээврийн хэрэгслээс ялгарах хорт хийг стандартын түвшинд байлгах, агаарын бохирдлын төлбөр төлөх, техникийн үзлэг, засвар үйлчилгээг байнга хийж байх	Уурхайд ашиглаж байгаа машин, хүнд мөхөнизмууд, тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг оншилгоонд хамруулахад тээврийн хэрэгслээс ялгарах хорт хий стандартын түвшинд байна. Техникийн үзлэг, засвар үйлчилгээг хуваарийн дагуу байнга хийж ажиллаа.	6,5 сая төг
3	Баяжуулах үйлдвэрт тоос барих төхөөрөмж суурилуулах	БНХАУ-аас тоос барих төхөөрөмж худалдан авахаар судалгаа хийж байна.	23 сая төг
4	Хүдэр бутлах болон машины хэсгийг битүүмжлэх, унжуулдаг хаалт хийх, хүдэр дамжуулах шугамын битүүмжлэлийг сайжруулах зэрэг боломжит шийдлүүдийг хэрэгжүүлэх	Хүдэр бутлах болон машины хэсэгт реминээр унжуулдаг хаалт хийж хүдэр дамжуулах шугамын битүүмжлэлийг сайжруулх арга хэмжээ өвч ажиллаа.	16 сая төг

	Дүн	47,5 сая төг
--	-----	--------------



3.2. Амьтны аймаг, хөрс, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
ХӨРС ОРЧИН			
1	Хурдны хязгаарыг 30км цагаас хэтрүүлэхгүй байх, тэмдэг тэмдэглэгээг байрлуулах	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлаж байх зорилгоор жолооч операторуудад сургалт сурталчилгааг хийж, зам дагуу тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг тогтоосон болон маршрут чиглэлийг заасан тэмдэглэгээ хийсэн .Ашиглахгүй болсон шороон замыг хутгуурт ачигчийн тусламжтай дагтаршуулан засварлаж, олон салаа зам гаргахгүй, замын тэмдэглэгээ хийж, автомашин тээврийн хэрэгсэлийн хурдыг хязгаарлаж ажиллаа.	2,3 сая төг
2	Үршил шимт хөрс хуулан авч тусгайлан овоолго байгуулж нөхөн сэргээлтэд хэрэглэхээр хадгалах	Ашиглалт явуулсан болон хаягдлын овоолго хийсэн талбайн үржил шимт хөрсийг тусад нь хуулж 5 м-ээс өндөргүй овоолон хадгалж байв. Овоолсон шимт хөрсийг салхинд хийсэх болон үерийн усанд урсахаас хамгаалахаар зохион байгуулсан.	31 сая төг
3	Уурхайн талбай дахь замын сүлжээг	Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг	171 сая төг

	сайжруулсан шороон зам болгох	цэгцтэй болгож сайжруулсан шороон зам тавьж үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тэмдэглэгээг тавьж тэмдэгжүүлэв.	
4	Тээврийн хэрэгслийн маршрутын бус замаар явахыг хориглох таних тэмдэг бүхий самбарууд, ус, хөрс, ургамал, мод зэргийг хамгаалах сурталчилгааны мэдээллийг байнга хийх	Маршрутын бус замаар явах хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх хөрс, ургамал, мод зэргийг хамгаалах талаар жолооч операторуудад удаа сургалт сурталчилгаа мэдээллийн ажлыг зохион байгуулж ажилласан.	6 сая төг
5	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын цэгийг байгуулахдаа хүчил үүсгэдэггүй, хүчилд тэсвэртэй, ус үл нэвчих материалыг ашиглах, шингэн хаягдал хальж асгархаас сэргийлэх, түвшинд байнгын хэмжилт хийх	Баяжуулах үйлвэрээс гарсан шатах, тослох материалыг зориулалтын ёмкст хадгалж, орчинд асгарч алдагдахаас сэргийлж хадгалах талбайг хатуу хучилттай болгож, бохирдсон хөрсийг цэвэрлэж, зайлуулах арга хэмжээг тухай бүрт нь авч хэрэгжүүлж ажиллаа.	14 сая төг
УРГАМЛАН НӨМРӨГ			
6	Ургамлын нөмрөг нь хуулагдах болон нөлөөлөлд өртөхгүй талбайнуудыг тодорхой болгох зурагжуулах	Ургамлан нөмрөгийг устах, талхлагдахаас сэргийлж, хүн, техникийн хөдөлгөөнд хязгаарлалт тавьж авто замуудаар зорчих хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж, шороон асгацууд бий болгохгүйгээр, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулан ажиллав. Нөлөөлөлд өртөхгүй талбайнуудыг тодорхой болгож 1:100000 масштабын зураг зүйн карт үйлдэж баталгаажуулсан.	3 сая төг
7	Ховор, ховордож байгаа болон хожим нөхөн сэргээлтэд ашиглах орон нутгийн ургамлыг Үр, ургал эрхтнээр ургуулан нүүлгэн шилжүүлэх	Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг орон нутгийн Ойн ангийн удирдлагуудтай хамтран зохион байгуулж ажиллахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	2 сая төг
8	Үйл ажиллагааны нөлөөлөлд өртөөгүй газруудад зөвшөөрөлгүй автомашин, машин	Нөлөөлөлд өртөөгүй газруудаар зөвшөөрөлгүй автомашин, машин механизмын хөдөлгөөнд хязгаарлалт тавьж зөвшөөрөгдсөн авто замуудаар зорчих	4,2 сая төг

	механизмын хөдөлгөөнийг хориглох	хөдөлгөөнийг хэвшүүлж хяналт тавьж, шороон асгацууд бий болгохгүйгээр, талбайн ашиглалтын зохион байгуулалтыг сайжруулан хөдөлгөөнийг хориглох тэмдэг , тэмдэглэлгээг хийсэн.	
АМЬТНЫ АЙМАГ			
9	Ан агнахыг хориглох	Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт ухуулга хийх ажлыг 7-р сард зохион байгуулж, амьтан хамгаалах талаар танин мэдэхүйн постер бэлтгэж уурхайн фэйсбүүк группт байршуулсан.	0,5 сая төг
10	Шинээр зам байгуулахдаа амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байхаар тооцон нэг түвшний гарц гарам байгуулах	Орон нутгийн замыг шинэчилэн технологийн замыг тавихдаа ан амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахгүй байхаар тооцож байгуулсан	1,2 сая төг
11	“Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр”-өөр Сэлэнгэ аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх	Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний дагуу навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.	2,7 сая төг

Замын тэмдэг тэмдэглэгээ



Шимт хөрсний овоолго



3.3.Усан орчин, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
1	Унд-ахуйд ашиглаж буй худгийг хашиж хамгаалах	Унд-ахуйд ашиглаж буй усны эх үүсвэр /худаг/-ийг хамгаалан 1.5х1.5м хэмжээтэй барилга байгууламж барьсан.	2,8 сая төг
2	Усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах	Усны тухай хуулийн дагуу усны эх үүсвэрт тоолуур тавиулахаар мэргэжлийн байгууллага болох Сэлэнгэ аймгийн “Цэнгэг-Ус” ХХК-д хүсэлт гаргасан.	1,4 сая төг
3	Боловсон ариун цэврийн байгууламжийг барилга бүрт шийдвэрлэж, бохир усыг соруулан зөвшөөрөгдсөн цэгт	Ажилчдын боловсон халуун ус, 00-ын бохирын цооногыг нэвчилт явагдахааргүй хөрсний ханыг бетоноор цутгаж ирмэг овоо бүхий цементэн сууртай болгож тохижуулсан. Халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.	15,2 сая төг

	хаядаг байхаар төлөвлөх		
4	Ахуйн бохир усыг шууд хөрс болон усанд нэвчирхээс сэргийлж хамгаалах	Ажилчидын цайны газраас гарсан бохирын байгууламж байгуулан шугам хоолой болон цооногт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.	6,8 сая төг
5	Уурхайн усыг зайлуулах, дахин ашиглах асуудал, ус цэвэршүүлэлт зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх	Уурхайн ашиглалтын явцад хөрсний болон завсарын ус гараагүй байна.	
ГАЗРЫН ГАДАРГА			
7	Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үед нийт талбайг цэвэрлэж, цооног нүхийг бөглөх, дүүргэх, хог хаягдал, техникийн эд анги үлдээхгүй байх	Өрөмдлөг болон тэсэлгээний бэлтгэл ажлын үед гарсан хог хаягдал, техникийн эд ангийг талбайгаас бүрэн цэвэрлэдэг	1,5 сая төг
8	Уурхайн зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Зориулалтын цэгээс өөр газарт хог хаягдал хаяхгүй байх талаар заавар ажилчдад сургалт зохион байгуулсан	0,6 сая төг
9	Уурхайн хана, гадаргууг урт хугацааны турш тогтвортой байхаар засч хэлбэршүүлэх, аюулгүй байдалд оруулах	Баяжуулах үйлдвэрийн операторын удирдлагын ажлын байр байрласан эгц эргийг налуу болгож хайргаар хучилт хийж суларч нурахаас сэргийлэх арга хэмжээ авсан.	1,1 сая төг

Ундны эх үүсвэр /худаг/




Ажилчдын цайны газар




Эрэгтэй ажилчдын душ, 00 газар



Эрэгтэй душ



Ариун цэврийн өрөө



Эмэгтэй ажилчдын душ



Бохирын цооног



Ахуйн хаг хаягдал



Түймэрийн зурвас



3.4.Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
	Ойжуулалт хийх	Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийн хүрээнд манай компани нь “Сэлэнгэ Ой Ан Төв” ХХК-тай Ажил гүйцэтгэх гэрээгээр хамтран ажиллаж гэрээний дагуу навчит модны суулгац тарьж ургуулан хамтран ажиллаж байна.	2,7 сая төг

3.5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох шаардлагын талаар судалгаа хийх, ажлын төлөвлөгөө, журам боловсруулах	Судалгааны явцад уурхайн бүсэд иргэд, малчид суурьшаагүй байна.	

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. 2024 он нь ашиглалтын эхний жил болох тул энэ онд техникийн нөхөн сэргээлт хийгдэхгүй бөгөөд биологийн нөхөн сэргээлтийг ашиглалтын 5 дахь жилээс хийхээр төлөвлөсөн. Харин уурхайн бүрдэл хэсгүүдийн шимт хөрсийг хуулж хадгална.



5.ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг төлөвлөсөн байдал	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний гүйцэтгэл
1	Болзошгүй аюул, осол	Эрсдэлийн сан бий болох	1 500 000 төгрөгийн сан үүсгэв.
2		Гал унтраах хэрэгслийг зохих газруудад	✓ Галын хор байршуулах 23 цэгийг тодорхойлж хангасан.

		байрлуулж байнгын бэлэн байлгах	✓ Галын сараа байршуулах 6 цэгийг тодорхойлж иж бүрдлийн дагуу байршуулсан
3	Галын аюул, хээрийн түймэр	Аюулын гарц заасан самбар, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	✓ Аюулын гарц заасан самбар тэмдэглэгээг ажилчдын цайны газрын 2 гарцанд ✓ Галын самбарыг ажилчдын цайны газар, баяжуулах үйлдвэрийн операторын өрөөнд ✓ Газын баллоны өрөөг тусад нь гаргаж галын аюулын тэмдэглэгээ, ил гал гаргахыг хориглох тэмдэг, тамхи татахыг хориглох тэмдэг ✓ Газын плетикины ойр аюулгүй ажиллагааны заварчилгааны самбар ✓ Цахилгааны шитнүүд болон цахилгаан хуваарилах байгууламжинд ил гал гаргахыг хориглох тэмдэг, тамхи татахыг хориглох тэмдэг ✓ Дэд станцын өндөр хүчдэлийн аюултай тэмдэг болон ил гал, тамхи татахыг хориглох тэмдэг ✓ Дэд станцын жижүүрт шаардагдах тусгай ХХХ-г хангаж байршуулсан ✓ Гэр, байрны хоорондын зайг хангаж тамхи татахыг хориглосон тэмдэглэгээг тус бүрд байршуулж аюулгүйн зайд тамхины цэг байршуулсан
4		Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтанд хамруулах	Нийт ажилчдад галын сургалтыг орж ажилтан нэг бүрийг галын хооронд үзлэг шалгалт хийх болон ТОШШ дүрмийн дагуу ажиллуулах дадлага хийлгэсэн
5	Хяналтаас гадуурх тэсэлгээний ажил	Тэсэлгээний ажлыг нарийн төлөвлөгөөний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэдэг байх	Тэсэлгээний ажил гүйцэтгэх компани ажилчдад ээжлжит бус зааварчилгаа өгч тэсэлгээний үеэр аюулгүйн зайг хангаж харуул томилон ажиллуулдаг Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн 2.2-2.3 заалтг мөрдөж тэсэлгээ хийж хэвшсэн
6		Тэсэлгээний үед ажилчдыг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлээр хангах	✓ Тэсэлгээний мэргэжлийн “Тэгш зорголон” ХХК-тай гэрээлж тэсэлгээ хийгддэг ✓ Тэсэлгээний үед бүх харуул болон тэсэлгээний ажилчдыг радио станцаар хангаж ажиллаж байна.

7	Хүйтэн салхи, шуурга, аянга цахилгааны осол	Хүчтэй салхи, шуурганы үед үзэгдэх орчин хязгаарлагдсан үед уурхайн тээвэрлэлт, тэсэлгээ зэрэг ажлыг түр хугацаанд зогсоох	Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн 4.1д заасны дагуу тээвэрлэлт хийж хэвшсэн. Аюултай үзэгдэл, үзэгдэх орчин хязгаарлагдсан үед уулын мастер, баяжуулах үйлдвэрийн ахлахууд эрх мэдлийн хүрээнд ажил зогсоох эрхтэй.
8		Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байршуулах	Аянгаа зайлуулагч баяжуулах үйлдвэрийн 2 талд, шатахуун нөөцлөх савны ойр 1, нийт 3 ширхэг аянга зайлуулагчийг байршуулуулсан
9	Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах	✓ “Алтан боломж” сургалтын төвөөс нийт ажилтны сургалт ✓ “Герман Монгол МСҮТ”-ээс даралтат савны эрх олгох сургалт ✓ “Арш хур” сургалтын төвөөс ажил олгогчийн сургалт
10	Машин техникийн осол	Жолооч бүрийг даатгалд хамруулах	Жолооч бүр жолоочийн хариуцлагын даатгалд даатгагдсан
11		Машины кабин бүрт эмийн сан, галын хор байршуулах	Машины кабин бүрд эмийн сан, галын хор байршуулсан. /Нийт 13 машинд/

ГАЛЫН АЮУЛ, ХЭЭРИЙН ТҮЙМЭР









ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГА, АЯНГА ЦАХИЛГААНЫ ОСОЛ




ХЯНАЛТААС ГАДУУРХ ТЭСЭЛГЭЭНИЙ АЖИЛ


№	Ажилтны овог нэр	Албан тушаал	Давтан зааварчилгаа өгсөн шалтгаан	Зааварчилгааны утга	Он сар өдөр	Зааварчилгаа өгсөн хүний албан тушаал нэр гарын үсэг	Ажилтны овог нэр	Албан тушаал	Давтан зааварчилгаа өгсөн шалтгаан
1	Хуучин Бай	Мастер	Хяналтын	1. ХХ Хэрэгсэл бүрт	24.07.26	Монгол	Хуучин Бай	Мастер	Хяналтын
2	Г. Нямдорж	Оператор	Болом	пүрхт, дов олсон		Монгол	Г. Нямдорж	Оператор	Болом
3	З. Батбаян	туслах	Тасалгааны	2. АА-ны дааварчилгаа		Монгол	З. Батбаян	туслах	Тасалгааны
4	Г. Валмиев	туслах	анх	авч карх хөтөлбөр,		Монгол	Г. Валмиев	туслах	анх
5			пүрхтөх	төрийн үйл зурт		Монгол			пүрхтөх
6				Баталгаатнуулах		Монгол			
7				3. Болом болом экскаватор		Монгол			
8				фигурын радиус, зам		Монгол			
9				машинд рүү орохгүй бх.		Монгол			
10				Бусад техникэд дэвсгэр		Монгол			
11				стандарт модоор,		Монгол			
12				догоор авч		Монгол			
13				4. Машинд орох үед		Монгол			
14				хурдан шилжилд АА-ны		Монгол			
15				давхар, дааварчилгаа		Монгол			
16				бүт ашиглах.		Монгол			
17				4. Хурдан болом машинд		Монгол			
18				догоор модоор далай		Монгол			
19				модоор		Монгол			
20						Монгол			
21						Монгол			
22						Монгол			



ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА



МАШИН ТЕХНИК



6.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэхэд хог хаягдал гарснаар тухайн газар нутгийг бохирдуулах, мөн ажиллаж амьдарч байгаа ажилчид, нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Уурхайн хог хаягдлыг дараах байдлаар ангилсан. Үүнд:

- 1.Ахуйн хэрэглээний хог хаягдал
- 2.Шингэн хог хаягдал
- 3.Хатуу хог хаягдал

Ахуйн хэрэглээний хог хаягдалд: Ажилчдын байрнаас гарах хог, цайны газраас гарах хаягдал, ажлын байрны хог хаягдлууд багтана. Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-тай №49/10 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Уулын ажлын дараа нийт ашиглалтын талбайн хогийг цэвэрлэн Ерөө сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.



Ахуйн хэрэглээний шингэн бохирын хаягдлыг цооног байгуулан түүнд зайлуулан ариутгалыг тогтмол хийж байна. Үүнээс гадна бие засах газрын битүүмжлэлийг сайн хийж, тогтмол ариутгал цэвэрлэгээ хийх арга хэмжээг авч ажилласан.



Хатуу хог хаягдалд: Уурхайн механик цех, токарийн суурь машин, засвар үйлчилгээ хийгдсэн машин механизмаас гарах хатуу хог хаягдлууд орно. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгайлан талбайд цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хурааж түүхий эд авах цэгт тушаахаар бэлтгэсэн

6.1.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушааж байх, хог хаягдлыг дахин ашиглах зэрэг хог хаягдлын хэмжээг багасгах арга хэмжээг авах	Уурхайн машин, техник засвар үйлчилгээ хийгдсэн машин механизмаас гарах хатуу хог хаягдлууд орно. Тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгайлан талбайд цуглуулж хог хаягдлын хэмжээг багасгах арга хэмжээ авч ажиллаа.	2,6 сая төг
	Сар бүр хог хаягдлаа тээвэрлэж зайлуулах	Ажилчдын байрнаас гарах хог, цайны газраас гарах хаягдал, ажлын байрны хог хаягдлууд багтана. Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-тай №49/10 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	1,2 сая төг
	Хог хаягдал түр хадгалах талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг ховоо бүхий цементэн суурьтай болгон тохижуулан	Ажилчдын цайны газар, халуун ус, 00-ын бохирын цооногыг нэвчилт явагдахааргүй хөрсгий ханыг бетоноор цутгаж ирмэг овоо бүхий цементэн суурьтай болгож тохижуулсан. Халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.	15,2 сая төг
	Бохирын цооногт 1м ³ бохирт 1л био бэлдмэл байхаар тооцож тогтмол ариутгал хийх	Ажилчидын цайны газраас гарсан бохирын шугам хоолой болон цооногт ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж байна.	0,8 сая төг
	Ашиглах тос, тосолгооны материалыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан УБ хотод НВОil хаягдал тос	Уурхайн хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээ хийгдсэний дараагаар сольсон тос масло, шүүр, ахуйн хэрэглээний бохирын ус гэх мэт хаягдал гардаг. Хаягдлыг битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан тушаахад бэлэн болсон	2,3 сая төг

	боловсруулах үйлдвэрт тушаах	
--	---------------------------------	--

7.БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Тухайн төслийг хэрэгжүүлсэнээс үүдэн байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зохих стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хязгаарт байгаа эсэхийг хянах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт хийх зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №21 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд стандартын хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар батлагдсан.

Дээрх шинжилгээнүүдийн хариу хэвийн гарсан бөгөөд шинжилгээний үр дүнг хавсралтаар оруулав.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эргэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг, Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2024 / № Х100

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас "Хүннү стиль" ХХК

Дээжийн тодорхойлолт Ерөө сум Бугант 3-р баг

Дээж авсан хүний нэр, албан тушаал БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл 1, Хөрс

Хүлээн авсан огноо 2024 - 09-24

Дээжийн тодорхойлох үзүүлэлт нефтийн бүтэцдэхүүн

Шинжилгээ хийж дууссан огноо 2024 - 09 - 30

Үр дүн:

№	Дээж авсан цэгийн нэр	РН	Нефтийн бүтэцдэхүүн мг/л
1	Засварын газар	8.94	Илрээгүй
	MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламж (X _h)	-	0.2

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хүннү стиль" ХХК-ний засварын газраас авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 5850:2008 стандарт дахь хүлцэх агууламжаас даваагүй байлаа.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер
Шинжилгээг хянасан БОШЛ-ийн эрхлэгч

С.Цэнджав
М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эргэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг, Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он 2024 /А105-106

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас "Хүннү стиль" ХХК

Дээжийн тодорхойлолт Ерөө сум Бугант 3-р баг

Дээж авсан хүний нэр, албан тушаал БОШЛ-ийн эрхлэгч М.Аягүл

Дээжийн тоо, төрөл 2, Агаарын дээж

Хүлээн авсан огноо 2024 - 09-26

Сорилтын арга, аргачлал MNS0017.2.5.12.2021, MNS0017.2.5.11.2021, MNS4046-88

Дээжийн тодорхойлсон үзүүлэлт хүүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тос

Шинжилгээ хийж дууссан огноо 2024 - 09 - 27

АГААРЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/м ³			
		Азотын давхар исэл (NO ₂)	Хүүхэрлэг хий (SO ₂)	Дундаж	Нийт тос
1	Камп	0.018	0.005	0.145	0.179
2	Балжуулах	0.022	0.006	0.169	0.254
	MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж	0.200	0.450	0.500	-

Дүгнэлт:
Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хүннү стиль" ХХК-ны уурхайн тосгон болон балжуулах үйлдэрийн орчноос авсан агаарын дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд агаарын чандарыг хянах MNS 4585:2016 стандартад заагдсан үзүүлэлтийн хүлцэх агууламжаас даваагүй байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инженер
Шинжилгээг хянасан БОШЛ-ийн эрхлэгч

С.Цэнджав
М.Аягүл

Хуулбарлан хэвлэхийг хориглоно
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эргэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он: 2024 / Х 101-102
 Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
 Дээжийн тодорхойлолт
 Дээж авсан хүний нэр, албан тушаал
 Дээжийн тоо, төрөл
 Хүлээн авсан огноо
 Дээжийн тодорхойлох үзүүлэлт
 Шинжилгээний аргын стандарт
 Шинжилгээ хийж дууссан огноо

"Хүннү стиль" ХХК
 Ерөө сум Бугат 3-р баг
 БОШЛ-ийн эрхлэгч М.Аягуу
 1. Хөрс
 2024 - 09 - 26
 агрохимийн үзүүлэлт
 MNS 3310:1991
 2024 - 09 - 30

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд, мг/кг							нэмэгд
		РН	ЕС	Фосфор	Сульфат	Чийг %	Нитрат	Аммоний азот	
1	Кемпийн орчим	6.20	3.24	18.7	51.7	1.08	1.3	Илрээгүй	1.4
2	Баяжуулах	8.17	3.55	19.3	52.6	1.10	2.4	Илрээгүй	1.3
	MNS 3297:2019 стандарт дахь ХХД	6-9			160.0	-	130.0	-	-

Дүгнэлт:
 Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах "Хүннү стиль" ХХК-ны уурхайн тосгон болон баяжуулах үйлдвэрийн орчмоос авсан хөрсний дээжинд химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 3297:2019 стандартад заагдсан үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инжнер... С.Цэнджав
 Шинжилгээг хянасан БОШЛ-ийн эрхлэгч... М.Аягуу

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорилтанд хүчинтэй.

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ

Сүхбаатар сум, Цагаан эргэгийн гудамж, 2-р багийн 2-р хэсэг. Утас: 7036-3983

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар он: 2024 / № У19
 Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
 Дээжийн тодорхойлолт
 Дээж авсан хүний нэр, албан тушаал
 Дээжийн тоо, төрөл
 Хүлээн авсан огноо
 Дээжийн тодорхойлох үзүүлэлт
 Шинжилгээ хийж дууссан огноо
 Үр дүн

Сэлэнгэ аймаг
 Ерөө сум "Хүстайн уурхай"
 Д.Даваадорж, менежер
 1. Ундны ус
 2024 - 04 - 29
 гол ин, биогений элемент
 2024 - 04 - 30

Стандартын дугаар	Шинжилгээ хийсэн элементүүд	Ундны ус	MNS 900:2018
MNS ISO 10523:2001	РН -орчин	7.66	6.5-8.5
CA3 Y 21:2012	Өнгө		20 градус
MNS 1097:1970	Кальци	36.5	100.0
MNS 1097:1970	Магни	16.3	30.0
MNS ISO 7150:2008	Аммоний азот	0.00	1.5
MNS 4430:2005	Төмөр нийт	0.04	0.3
MNS 4424:2005	Хлор	0.7	350.0
MNS 6271:2011	Сулфат	32.9	500.0
MNS 6779:2019	Нитрит	0.000	1.0
MNS 6843:2020	Нитрат	1.05	50.0
MNS 6831:2020	Гидрокарбонат	252.4	
MNS ISO 6059:2005	Хатуулаг	3.16	7.0
MNS 6833:2020	Перманганатын исэлдэх чанар	0.8	
MNS 6272:2011	Фтор	0.93	0.7-1.5
MNS 1097:1970	Зэвсжилт	364.8	
CA3 Y 20:2012	Na+	45.9	
MNS ISO 6878:2001	Фосфор	0.012	3.5
MNS ISO 7888:1999	EC, µs/cm	436.0	1000.0
MNS 6835:2020	Булингар	0.49	5.0
Цэвэр		5.09	
MNS ISO 11063:2001	Хром+	0.000	

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах иргэн "Хүннү стиль" ХХК-ны Хүстайн уурхайн нутгийн ундны уснаас дээж авч химийн шинжилгээ хийж үзэхэд MNS 900:2018 стандартад дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байлаа.

Шинжилгээ хийсэн БОШЛ-ийн инжнер... М.Өнөржаргал
 Шинжилгээг хянасан БОШЛ-ийн ерөнхий инжнер... М.Аягуу

Хуулбарлан хэвлэхийг хориглоно.
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорилтанд хүчинтэй.

8.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕНЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд бий болж байна.

Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалтыг 6 болон 8-р сард 2 удаа хийж гүйцэтгэсэн. Үр дүнд ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол аливаа гэмтэл ослыг бууруулсан. Байгаль орчны удирдлагын тогтолцоо, нийгмийн хариуцлага болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, ирээдүйд гарч болзошгүй байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварыг тодорхойлох, тэдгээрийн арилгах арга хэмжээ авах замаар учирч болзошгүй алдагдал, хохиролоос сэргийлэхэд чиглэсэн дүгнэлт, зөвлөмжтэй болсон.

Байгаль орчны удирдлагыг дараах чиглэлээр хэрэгжүүлж ажиллав.

Үүнд:

Байгаль орчныг хамгаалах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан уурхайн ажиллагсдад ХАБЭА-н хичээл болон зааварчилгааг тогтмол өгч ажиллав.

Уурхайн бүх ажлыг ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу явуулсан.

Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл /газар хөдлөлт, үер, салхи шуурга/ болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг 8-р сард зохион байгуулав.

Уурхайн ажиллагсдын дунд байгаль хамгаалах талаар ухуулга яриа, сурталчилгааны

ажлыг 8-р сард зохион байгуулсан.

Уурхайн кемпийн эргэн тойронд галын аюулаас урьдчилан сэргийлэх зурвас татаж хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгаж ажилласан.

Уурхайн ухааш, болон хамгаалалтын суваг шуудуу нь хүн, мал, амьтан унах, осолдохоос сэргийлсэн хаалт хийж эргэн тойронд нь анхааруулах, хориглох санамж байршуулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, ус, хөрс, агаарын бохирдол, хөрсний эвдрэл,элэгдэл, усны нөөцийн байдалд хяналт тавих зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №21 тоот гэрээний дагуу хамтран ажиллав.

Шатахуун хадгалах, түгээх станцын галын аюулгүй ажиллагааг найдвартай хангаж, тос шатахуун алдах, хаях, уурших явдлыг гаргахгүй байхад онцгой анхаарч ажилласан.

8.1.Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авах арга хэмжээ	Гүйцэтгэл	Зардал
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шижилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд харьцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор Сэлэнгэ аймгийн “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-тэй байгуулсан №21 тоот гэрээний дагуу Байгаль орчны төлөв байдлын хяналт шинжилгээг ус, хөрс, агаараас дээж авч шинжлэхэд стандартын хэмжээнд байгаа нь шинжилгээний хариугаар батлагдсан.	0,6 сая төг
2	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулах	Байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагаатай холбогдсон сургалтыг 6 болон 8-р сард 2 удаа хийж гүйцэтгэсэн. Үр дүнд ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдол аливаа гэмтэл ослыг бууруулсан.	2,5 сая төг
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шижилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үзэж шалгах ажлын хэсгийн үзлэг шалгалтанд хамрагдаж тайлан мэдээгээр хангаж ажилласан.	0,2 сая төг

	хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биелэлтийг дор бүр дүгнэж, үр дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх		
	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдал, чанарыг хянан мэргэжлийн байгууллагаар шалгалт хийлгэх	Газрын төлөв байдал, чанарыг хянан баталгааг хийлгүүлэхээр мэргэжлийн байгууллагын сонгон шалгаруулалт зохион байгуулаар төлөвлөж байна.	8 сая төг
8	Хог хаягдлын тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх	Хог хаягдлын менежментийн ажлын хүрээнд ахуйн хог хаягдлаа Сэлэнгэ аймгийн Ерөө сумын “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ-тай №49/10 тоот Хог хаягдлын гэрээ байгуулан хамтран ажиллаж, гэрээний дагуу ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаясан.	1,2 сая төг
10	Уурхайг тойруулан үерийн усны хамгаалалтын суваг болон далан байгуулах	Баяжуулах үйлдвэр болон шатахуун түгээх станцыг тойруулан үер усны эрсдлээс хамгаалж хамгаалалтын суваг татсан.	0,6 сая төг

БОМТ-ний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлганах

№	Оролцогч талууд	Тайлганах хэлбэр	Агуулга	Хугацаа	Хэрэгжилт
1	Орон нутгийн иргэдэд	Хэлэлцүүлэг	Төслийн үйл ажиллагаа болон БОХ, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажлууд	Жил бүрийн 10 сард	Уурхайн үндсэн үйл ажиллагаа, нөхөн сэргээлтийн явц, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажлын танилцуулгыг газар дээр нь ирж танилцсан иргэд, олон нийтийн төлөөлөл, Ерөө сумын Төрийн захиргааны байгууллага, Ерөө сумын ахмадын хороо, Экологийн цагдаа зэрэг

					газруудад дэлгэрэнгүй мэдээллээр хангаж ажилласан.
2	Аймгийн өайгаль орчны газарт	Тайлганах	Төслийн үйл ажиллагаа болон БОХ, сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	БОМТ-ний биелэлтийн тайлангаа хуулинд заасан хугацаа буюу 10-р сард багтаан аймгийн БОАЖГ-т хүргүүлдэг.
3	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан төлөвлөгөө батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлын биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12 сарын 31-ний дотор	